

Тайлан модуль Системтэй ажиллах дараалал

ДБУМС-д хэрэглэгчийн нэр, нууц үгийг ашиглан нэвтэрсний дараа эдгээр энгийн 3 алхмын дагуу модультай ажиллана.

1. Системийн нүүр хуудас
2. Модулийн нүүр хуудас
3. Үйлдэл хийх цонх

- Системийн нүүр хуудас

Нүүр хуудас нь үйл ажиллагааны чиглэлийг бүлэглэсэн системийн модуль сонгох цэсүүдээс бүрдэнэ. Жишээ нь манай байгууллага, суралцагч, сургалтын хөтөлбөр, сургалтын агуулга, багш, сургалтын орчин,... гэх мэт.

- Модулийн нүүр хуудас

Ерөнхий цэс дээр дарахад тухайн үйл ажиллагааны чиглэлээр системд бүртгэсэн мэдээллийг жагсаалт хэлбэрээр харуулна. Мөн жагсаалтаас олон төрлийн нөхцлөөр хялбар, нарийвчилсан хайлт хийх боломжтой юм.

- Үйлдэл хийх цонх

Жагсаалтын цонхноос хийх үйлдлийг сонгосноор тухайн үйлдлийн дэлгэрэнгүй цонх руу шилжинэ. Үйлдэл нь шинэ бүртгэл хийх, мэдээллийн өөрчлөлт хийх,... зэрэг олон төрлийнх байх ба тухайн үйлдлээс хамаарч ажиллах цонх өөр өөр гарч ирнэ.

Тайлан модуль Системийн нүүр хуудастай ажиллах

Системийн нүүр хуудас дараах бүтэцтэй байна.

Тайлбар:

- 1. Системийн толгойн мэдээлэл
- 2. Системийн ажлын талбар
- 3. Системийн хөлний мэдээлэл

1. Системийн толгойн мэдээлэл

Системийн толгойн мэдээлэл нь системийн нэр, нэвтэрсэн хэрэглэгчийн байгууллагын нэр, нүүр хуудасруу үсрэх үйлдэл, нэвтэрсэн хэрэглэгчийн цэс болон онлайн тусламжийн системрүү шилжих үйлдэл зэргээс тогтоно.

Тайлбар:

- **Системийн нэр**

Дээд Боловсролын Удирдлагын Мэдээллийн Системийн нэр байна.

- **Байгууллагын нэр**

Системд нэвтэрсэн хэрэглэгчийн байгууллагын нэр байна.

- **Нүүр хуудасруу шилжих үйлдэл**

Ямар ч үйлдэл хийх цонхруу орсон байсан ч үйлдэл нь нүүр хуудасруу шилжүүлнэ.

- **Системд нэвтэрсэн хэрэглэгчийн нэр, хэрэглэгчийн цэс**

Системд нэвтэрсэн хэрэглэгчийн нэр байх ба энэ хэсэг дээр дарахад хэрэглэгчийн цэс гарч ирнэ. Хэрэглэгчийн цэснээс системээс гарах, хэрэглэгчийн тохиргоо,... зэрэг үйлдлүүд хийж болно.

- **Системийн онлайн тусламжруу шилжих үйлдэл**

Онлайн тусламжийн систем-рүү шилжих үйлдэл хийнэ.

2. Системийн ажлын талбар

Системийн ажлын талбар хэсэгт тухайн сонгогдсон цэсний ажиллах талбарыг харуулах ба хэрэв нүүр хуудас сонгогдсон бол модуль сонгох цэс гарч ирнэ.

Тайлбар:

- **Модуль сонгох цэс**

Манай байгууллага, Суралцагч, Багш,... зэрэг системийн модуль сонгох цэс байна.

3. Системийн хөлний мэдээлэл

Системийн хөлний мэдээлэл хэсэгт системийн оюуны өмчийн мэдээллийг харуулна.

Тайлбар:

- **Оюуны өмчийн мэдээлэл**

Дээд Боловсролын Удирдлагын Мэдээллийн Системийн оюуны өмчийн мэдээлэл байна.

Тайлан модуль Модулийн нүүр хуудастай ажиллах

1. Модулийн толгойн мэдээлэл

Модулийн толгойн мэдээлэл нь модулийн нэр, модулийн дэд хэсэг болон модуль хаах үйлдэл зэргээс тогтоно.

Тайлбар:

- **Модулийн нэр**

Системийн сонгогдсон модулийн нэр байна.

- **Модулийн дэд хэсэг**

Тухайн модуль нь хэд хэдэн дэд хэсгээс бүрдэх ба ихэвчлэн хянах самбар, жагсаалт,... зэрэг хэсгээс бүрдэнэ.

- **Модуль хаах үйлдэл**

Энэ үйлдэл нь модулийн цонхыг хааж нүүр хуудасруу шилжүүлнэ.

2. Модулийн ажлын талбар

Модулийн ажлын талбар нь модулийн дэд хэсэгт ямар дэд хэсэг сонгогдсон байхаас хамаарч тухайн дэд хэсгийн ажиллах талбарыг гаргана.

Хэрэв модулийн дэд хэсгээс жагсаалт сонгосон бол ажлын талбар хэсэгт тухайн модулийн жагсаалтыг, эсвэл хянах самбар сонгосон бол хянах самбартай ажиллах талбарыг тус тус харуулна.

3. Жагсаалт, хайлттай ажиллах

Жагсаалт, хайлттай ажиллах хэсэгт мэдээллийг оновчтой хайх, нарийвчлан шүүх болон тухайн мэдээлэл дээр үйлдэл хийх боломжийг олгоно.

Жагсаалт, хайлтын цонх нь дараах бүтэцтэй байна.

Тайлбар:

- **Түлхүүр үгээр хайх**

Жагсаалтаас ямар нэгэн түлхүүр үгээр хайх боломжийг олгоно. Жишээ нь суралцагчийн жагсаалтнаас регистрийн дугаар, овог, нэр, мэргэжлийн чиглэл,... зэргээр хайж болно.

- **Нарийвчилсан шүүлтийн хэсэг**

Нарийвчилсан шүүлт нь хайлтын үр дүнг нарийвчлан тодорхойлох боломжийг олгох ба тухайн жагсаалтад боломжтой шүүлтийн төрөл болон шүүх утгаар шүүлт хийнэ.

- Нарийвчилсан шүүлтийн төрөл
- Нарийвчилсан шүүлтийн утга
- Жагсаалтын толгойн хэсэг

Жагсаалтын толгойн хэсэгт тухайн жагсаалтын нэр, тухайн жагсаалт дээр хийх боломжит үйлдлийн сонголтууд байна.

- Жагсаалтын нэр
- Жагсаалт дээр хийх үйлдлүүд
- Хайлт, шүүлтийн мэдээлэл

Хайлт хийх болон нарийвчилсан шүүлт хийснээр хайлтын олдоцийн тоо, ямар ямар шүүлт хийснийг илэрхийлсэн мэдээллээр хангана.

- Хайлтын олдоцийн тоо
- Нарийвчилсан шүүлт
- Хайлт, шүүлтийн үр дүн

Хайлт болон шүүлт хийснээр олдсон олдоцийн мэдээллийг харуулах ба тухайн мэдээлэл дээр үйлдэл хийх боломжийг олгоно.

- Үйлдэл хийх цэс
- Түгжсэн багана
- Хуудасны дугаар
- Хуудас шилжих
- Хуудаслах тоо

4. Хянах самбартай ажиллах

Хянах самбар нь тухайн модулийн мэдээлэл дээр хяналт, шинжилгээ хийх боломжийг олгох ба **real-time** байна.

Хянах самбар нь дараах бүтэцтэй байна.

Тайлбар:

- Хянах самбарын толгойн мэдээлэл

Хянах самбар нь агуулгаасаа хамаарч нэг болон хэдэн хуудсаас бүрдэнэ.

- Хянах самбарын хуудас сонгох хэсэг
- Хянах самбарын хуудасны мэдээлэл

Сонгогдсон хуудас нь хэд хэдэн **анализийг** агуулах ба тухайн хуудас дээрх бүх анализ дээр зэрэг шүүлт хийх боломжтой байна.

- **Анализ**

Мэдээлэл дээр ойлгомжтой графикаар хяналт, шинжилгээ хийх боломжийг олгоно. Анализ нь нэр, төрлөөс хамаарч харагдах байдал нь өөр өөр байна.

- **Анализын нэр**
 - **Анализын график**
-

5. Тайлантай ажиллах

Тайлан нь тухайн модулийн мэдээлэл дээр дэлгэрэнгүй комплекс анализ хийх боломжийг олгох ба цаг хугацааны давтамжтай мэдээлэл хадгалах дата агуулахтай холбогдож ажиллана.

Тайлантай ажиллахад дараах ойлголтуудыг мэдэх шаардлагатай. Үүнд:

- Тайлангийн зохион байгуулалт
- Тайлангийн бүтэц

Тайлангийн зохион байгуулалт

Тайлангийн зохион байгуулалт дараах бүтэцтэй байна.

Тайлбар:

- **Тайлангийн каталогийн хиерархи**

Тайлан заавал нэг каталогт хамаарах ба нэг каталог нь нөгөө каталогтоо хиерахи байдлаар харъяалагдаж болно.

- **Сонгогдсон каталог**
- **Сонгогдсон каталогийн мэдээлэл**

Каталогийн хиерархиас каталог сонгоход тухайн каталогт харъяалагдах тайлан болон каталогийг харуулна.

- **Сонгогдсон каталогийн нэр**
- **Хайлт, шүүлт хийх**
- **Харъяалагдах тайлан болон каталог**

Тайлангийн бүтэц

Тайлангийн зохион байгуулалтын хэсгээс тайланг сонгоход дараах цонх харагдана.

Суралцагч нарийвчилсан мэргэжлийн чиглэлээр Буцах

Тайлан > Суралцагч > Мэргэжлийн чиглэл > ... Хэвлэх Татах Тохиргоо 100

Тайлангийн шүүлт

Ерөнхий мэргэжлийн чиглэл
All

Төрөлжсөн мэргэжлийн чиглэл

Бүгд
 Боловсрол
 Урлаг
 Хүмүүнлэг
 Хэл
 Нийгмийн болон зан үйлийн шинжлэх у
 Сэтгүүлзүй, мэдээлэл
 Бизнес ба удирдахуй
 Эрхзүй
 Биологи ба холбогдох шинжлэх ухаан
 Хүрээлэн буй орчин

Нарийвчилсан мэргэжлийн чиглэл

Бүгд
 Боловсролын шинжлэх ухаан
 Багш, оургуулийн өмнөх насны боловср
 Багш, бага ангийн боловсрол
 Багш, мэргэжлийн
 Дуу дүрсний техник болон медиа үйлдв
 Хувцас загвар, интерьер ба үйлдвэрлэл
 Дүрслэх урлаг
 Гар урлал
 Хөгжим, тайз дэлгэцийн урлаг
 Урлагийн салбар дундын хөтөлбөр

Хүйс

Бүгд
 Эрэгтэй
 Эмэгтэй

Боловсролын түвшин

Бүгд
 Дипломын боловсрол
 Бакалаврын боловсрол
 Магистрын боловсрол
 Докторын боловсрол

Тайлан бодох
Шинэчлэх

СУРАЛЦАГЧДЫН ТОО НАРИЙВЧИЛСАН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР
2018-2019 оны хичээлийн жил

№	Мэргэжлийн чиглэл	Нийт	Үүнээс:		Боловсролын түвшин			
			Эмэгтэй	Эрэгтэй	Диплом	Бакалавр	Магистр	Доктор
Боловсролын шинжлэх ухаан								
1	Боловсрол судлал	3,106	2,561	545	0	157	2,455	494
2	Боловсролын удирдлага	1,679	1,461	218	0	0	1,679	0
3	Сургалтын технологи	24	23	1	0	0	24	0
Бүгд		4,809	4,045	764	0	157	4,158	494
Хувиар		100%	84.11%	15.89%		3.26%	86.46%	10.27%

Суралцагчдын тоо нарийвчилсан мэргэжлийн чиглэлээр Хуудас: 1

Тайлбар:

1. Тайлангийн толгойн мэдээлэл

Сонгогдсон тайлангийн нэр болон буцах товчлуур байх ба буцах товчлуур дээр дарахад өмнөх хуудасруу шилжинэ.

2. Тайлангийн дэд мэдээлэл

Тухайн тайлангийн байршлын мэдээлэл болон хэвлэх, татаж авах, тохиргоо хийх,... зэрэг тайлан дээр хийгдэх үйлдлүүдийг агуулна.

- 2.1 Тайлангийн байршил
- 2.2 Тайлан дээр хийх үйлдэл

3. Тайлангийн шүүлт

Тайлангийн мэдээллийг харуулахдаа тухайн тайлангаас хамаарсан нэмэлт хайлт, шүүлт хийх боломжтой. Шүүлт хийсний дараа **Тайлан бодох** товчлуур дээр дарж тайлангаа бодуулна.

Хэрэв хайлт болон шүүлтээ арилгах бол **шинэчлэх** товчлуур дээр дарна

- **3.1 Шүүлтийн төрөл**
 - **3.2 Шүүлт хийх утга**
 - **3.3 Тайлан бодох болон Шинэчлэх үйлдэл**
-

Тайлан модуль Үйлдэл хийх цонхтой ажиллах

Үйлдэл хийх цонхыг тухайн модулийн жагсаалтнаас сонгож хийнэ.

Жагсаалт, хайлттай ажиллах хэсгийн **3.2 Жагсаалт дээр хийх үйлдлүүд** болон **5.1 Үйлдэл хийх цэс** хэсгийг харна уу.

Үйлдэл хийх цонхны дараах бүтэцтэй байна.

Тайлбар:

- **Үйлдлийн цонхны толгойн мэдээлэл**

Үйлдэл хийх цонх нь тухайн үйлдлээс хамаарч өөр өөр байна.

- **Үйлдлийн цонхны нэр**
- **Цонхон дээр хийх нэмэлт үйлдлүүд**
- **Үйлдлийн агуулга**

Үйлдлийн агуулга нь тухайн үйлдлээс хамаарч өөр өөр байна.
